

УЛААНБААТАР ХОТ
АМГАЛАН
ДУЛААН
БАТЛАВ
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.МӨНХӨӨ

БАТЛАВ
БЭЦ ТРАНС ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Н.ОЮУНЧИМЭГ

**ХҮНД МАШИН МЕХАНИЗМУУДЫН СЭЛБЭГ ХУДАЛДАХ,
ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

20²³ оны 05-р сарын 04 өдөр

Дугаар 2023/31

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө, нөгөө талаас Бэц транс ХХК-ийг төлөөлж захирал Н.Оюунчимэг /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29-р зүйлийн 29.2 дахь заалт, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1 Нийлүүлэгч нь “Хүнд машин механизмуудын сэлбэг” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан нэр төрөл, тоо хэмжээ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу захиалагчийн агуулахад нийлүүлнэ.

Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1 Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 30 хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

3.1 Энэ гэрээний нийт үнэ 110,934,832/ Нэг зуун арван сая есөн зуун гучин дөрвөн мянга найман зуун гучин хоёр/ төгрөг бөгөөд үнийн дүнд гааль онцгой албан татвар, захиалагчийн агуулахад хүргэх тээврийн зардал, НӨАТ бүгд орсон байна.

3.2 Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.

3.3 Барааг хүлээлгэн өгсөний дараа бараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн 90 хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Голомт банкны 1415118135 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

4.1 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.

4.2 Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, тоо хэмжээ, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд

Захиалагч:



1/6

Нийлүүлэгч:



хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.

- 4.3 Барааг захиалагчийн агуулахад ирсний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана. Буцаах зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.
- 4.4 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг АХММХМ инженер Н.Сайнбилэг хариуцан ажиллана. Утас-98109919.
- 4.5 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг БЭЦ транс ХХК-ийн захирал Н.Оюунчимэг хариуцан ажиллана. Утас- 88105228.

Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол

- 5.1 Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2 Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед гэмтэхээс хамгаалсан сав, баглаа, боодолтой ашиглагдаагүй, зэврээгүй байна. Нийлүүлэх сэлбэг, хэрэгсэл, хөдөлгүүр нь 2022 оноос хойш үйлдвэрлэгдсэн шинэ байна.
- 5.3 Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой
- 5.4 Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5 Нийлүүлэгч нь нийлүүлсэн сэлбэг, хэрэгсэлийг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш 6 /зургаа/-н сарын баталгаа өгнө. Хөдөлгүүрийг ашиглаж эхэлснээс хойш 1 /нэг/ жилийн баталгаа өгнө. Батаалгаат хугацаанд нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан чанарын асуудлыг өөрийн зардлаар засаж залруулах, сольж өгөх үүрэгтэй.
- 5.6 Барааг дараах баримт бичиг дагалдана. Үүнд:
 - Барааны чанарын гэрчилгээ

Зургаа. Бараа хүлээн авах

- 6.1 Нийлүүлэгч нь ачигдсан барааг захиалагчийн агуулахад хүргэх ба захиалагч талаас бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2 Нийлүүлэгч нь барааг захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд гэрээний хугацаа дуусахаас өмнө талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

Найм. Гэрээг цуцлах үндэслэл

- 8.1 Нийлүүлэгч нь барааг энэхүү гэрээний 2.1-т заасан материал нийлүүлэх хугацаанаас хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид

Захиалагч:



2/6

Нийлүүлэгч:



албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцлана.

8.2 Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

Ес. Бусад нөхцөл

- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 2 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд 1 удаа сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨХК-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Э.МӨНХЖАРГАЛ

СЭЗХ-ИЙН ДАРГА
БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ

Ө.УДВАЛ

АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Г.БАТТУЛГА

АХММХМ ИНЖЕНЕР

Н.САЙНБИЛЭГ

ХУУЛИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Г.САРУУЛ

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :

ХАНГАМЖИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Ш.ГАНТУЛГА

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



БЭЦ ТРАНС ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Н.ОЮУНЧИМЭГ

Хаяг: Улаанбаатар хот, БЗД, 8-р хороо 521-55 тоот
Утасны дугаар: 88105228.
РД: 6278426

Захиалагч:

3/6

Нийлүүлэгч:

Нийлүүлэх барааний жагсаалт

№	Бараа материалын нэрс	Марк тип	Гарал үүсэл	Тоо	СЭЖИХ ХЭМЖЭЭ	ХЭМЖИХ НЭГЖ	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн нийт НӨАТ-тай үнэ
1	Урд исдүцний сальник	86CL6395	БНХАУ	4		ш	46,536	186,144.00
2	Хойд исдүцний сальник	190*220*30	БНХАУ	8		ш	46,536	372,288.00
3	Урд исдүцний шарик	K2841A	БНХАУ	12		ш	56,000	672,000.00
4	Хойд исдүцний шарик	30312	БНХАУ	16		ш	56,000	896,000.00
5	Депренцал	AZ9231320271	БНХАУ	1		КОМ	924,000	924,000.00
6	Урд исдүцний сальник	140/160	БНХАУ	2		ш	50,400	100,800.00
7	Хойд исдүцний сальник	190/220	БНХАУ	4		ш	56,000	224,000.00
8	Пирда диск	clutch /weilima	БНХАУ	1		КОМ	784,000	784,000.00
9	Пирда диск/	420мм	БНХАУ	2		КОМ	784,000	1,568,000.00
10	Пайлц	ф50мм/13см	БНХАУ	4		ш	224,000	896,000.00
11	Пайлц	ф50мм/16см	БНХАУ	2		ш	224,000	448,000.00
12	Пайлц	ф70мм/18см	БНХАУ	1		ш	224,000	224,000.00
13	Пайлц	ф100мм/20см	БНХАУ	2		ш	224,000	448,000.00
14	Пайлц	ф60мм/13см	БНХАУ	2		ш	224,000	448,000.00
15	Пайлц	ф70мм/22см	БНХАУ	2		ш	224,000	448,000.00
16	Гидрийн Шланк	EN853 2S Dn25	БНХАУ	2		ш	784,000	1,568,000.00
17	Гидрийн Шланк	Hydraulic[XIA MEN	БНХАУ	1		ш	784,000	784,000.00
18	Хийн автомат	0408-615B	БНХАУ	1		ш	448,000	448,000.00
19	Агаар шүүгч	JB/T9756-2004	БНХАУ	4		ш	112,000	448,000.00
20	Нумны гулгаа	6071	БНХАУ	6		ш	78,400	470,400.00
21	Кабины саран гарны тулк	Хово 336	БНХАУ	6		ш	89,600	537,600.00
22	Нэмэлт гэрэл	P20	БНХАУ	2		ш	112,000	224,000.00
23	Дугуйны боолт/шпилк/	№32	БНХАУ	60		ш	22,400	1,344,000.00
24	Маслын шүүр	JX1016	БНХАУ	2		ш	33,600	67,200.00
25	Түлшний шүүр	5023	БНХАУ	4		ш	44,800	179,200.00

Захиалагч:



4/6

Нийлүүлэгч:




26	Компрессорын агаар шүүгч	JB/T9756	БНХАУ	2	ш	89,600	179,200.00
27	Кабины халаагч	AIRD5/24V40 W	БНХАУ	2	ш	560,000	1,120,000.00
28	Кабины амортизатор	A7	БНХАУ	4	ш	224,000	896,000.00
29	Будаатай шүүр	Хово 3368 Nord benz	БНХАУ	6	ш	112,000	672,000.00
30	Помп/ усны/	8PK sorl	БНХАУ	1	ш	448,000	448,000.00
31	Стартер	Valeo SD3013	БНХАУ	1	ш	784,000	784,000.00
32	Түлшний шүүр	1000 442956	БНХАУ	3	ш	44,800	134,400.00
33	Маслын шүүр	JX1023	БНХАУ	2	ш	22,400	44,800.00
34	Динам	P2613551	БНХАУ	1	ш	448,000	448,000.00
35	Кропны тосны шүүр	20000/400	БНХАУ	1	ш	78,400	78,400.00
36	Гидрийн насос	44C0004-A1	БНХАУ	1	ш	1,769,600	1,769,600.00
37	Тормосны аппарат	50C0011 ZL50	БНХАУ	1	КОМ	224,000	224,000.00
38	Суудал	47CШ346- A1	БНХАУ	1	ш	784,000	784,000.00
39	Дохионы речак		БНХАУ	1	КОМ	112,000	112,000.00
40	Харандаан голны шаариг	75*95*20	БНХАУ	2	ш	112,000	224,000.00
41	Үнсний буулгах шланк/төмөр угастай/	Ф100/6м/	БНХАУ	2	ш	896,000	1,792,000.00
42	Клемний толгой		БНХАУ	6	ш	11,200	67,200.00
43	Хий холбогч/шланкны/	/6мм/ 14мм/	БНХАУ	20	ш	5,600	112,000.00
44	Их гэрлийн ламп	H4 24V 70W	БНХАУ	50	ш	33,600	1,680,000.00
45	Подворын ламп	H1 24V 70W	БНХАУ	100	ш	22,400	2,240,000.00
46	Арааны речакны толгой	A7O-466	БНХАУ	2	ш	72,800	145,600.00
47	Хийн шланк	Дугуй хийлэгч/10м/	БНХАУ	3	ш	95,200	285,600.00
48	Үндсэн амортизатор	KP-ТРАК А7	БНХАУ	12	ш	168,000	2,016,000.00
49	Үнс буулгах хаалт	ф125	БНХАУ	6	ш	173,600	1,041,600.00
50	Муфт шарик	6019/ A7	БНХАУ	2	КОМ	224,000	448,000.00
51	Нумны сорочик	Хово 336, Nord benz	БНХАУ	4	КОМ	134,400	537,600.00
52	Урд гар	хово 336	БНХАУ	4	ш	123,200	492,800.00
53	Дугуй хийлэгчийн	Хошуу, Урэгч, Буу	БНХАУ	4	КОМ	106,400	425,600.00
54	Ёмкосны тагны жийрэг	Ф45.8см	БНХАУ	3	ш	84,000	252,000.00
55	Арын их гэрэл	Хово 336, Nord benz	БНХАУ	6	КОМ	84,000	504,000.00

Захиалагч:



5/6

Нийлүүлэгч:

56	Дугуйн нөхөөс	/хайрцаг/	БНХАУ	20	ш	22,400	448,000.00
57	Дугуйн цавуу	/хайрцаг/	БНХАУ	10	ш	22,400	224,000.00
58	Олгой	22/R20	БНХАУ	30	ш	123,200	3,696,000.00
59	Олгойны элгэвч	22/R20	БНХАУ	15	ш	78,400	1,176,000.00
60	Фланц	Φ100	БНХАУ	4	ш	179,200	716,800.00
61	Кольцо сальник	IDCC.RU	БНХАУ	1	ш	56,000	56,000.00
62	Шайв	шланкны	БНХАУ	1	ш	44,800	44,800.00
63	Компрессор/хий хураагуур/	НУСW-10/2 1070*653*630	БНХАУ	1	ш	560,000	560,000.00
64	Гал хамгаалагч	/10A-502A/	БНХАУ	2	ш	61,600	123,200.00
65	Турбо	2.5L D4CB CRDI	БНХАУ	1	ш	3,528,000	3,528,000.00
66	Дугуй	20R- 12/6PR,8PR	БНХАУ	8	ш	1,288,000	10,304,000.00
67	Дугуй	/23R.5.25/	БНХАУ	4	ш	3,360,000	13,440,000.00
68	ADBLUE/систем салгах	Компьютер /программчи л/	ОХУ	1	КОМ	2,750,000	2,750,000.00
69	Мотор/ шинэ/	WD 615 IFN 247KW2200r/m in	БНХАУ	1	КОМ	39,200,000	39,200,000.00
	ДҮН						110,934,832.00

Амгалан дулааны станц ТӨХК-ийн

АХММХ-ийн инженер



Н.Сайнбилэг



БЭЦ транс ХХК-ийн

захирал

Н.Оюунчимэг

Захиалагч:



6/6

Нийлүүлэгч:

